



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/044/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2025 он

Дарга тэргүүлэх аудитор:

Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2025.08.25 № 29
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ТӨВИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Л.ЖАМБААСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь 2024 онд бараа материалын хөдөлгөөнийг тухай бүр батлагдсан маягтаар бүртгээгүй, түүнд хэрэгжүүлэх дотоод хяналт хангалтгүй байна. Тухайлбал:

1. Тээвэр шатахууны тайланд 4,756.7 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас /спидометрийн заалтгүй, гүйцэтгэсэн ажил үүргийг бичээгүй, зарцуулсан шатахууны тооцоог хийгээгүй/, холбогдох заавар журмын дагуу бүртгэлийг үнэн зөв хөтлөөгүй. 616.8 мянган төгрөгийн шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан.
2. Бусад хангамжийн материал дансны үлдэгдлийг бараа материалын тодруулга тайланд тайлагнаагүй, нярвын тайланг бэлтгээгүй.
3. Тусгай зориулалтын материал данснаас 194.7 мянган төгрөгийг зарцуулахдаа анхан шатны баримтад үндэслээгүй, 12 дугаар сарын тайланг бэлтгэхгүйгээр 1,642.0 мянган төгрөгийн орлого бүртгэсэн.
4. Бичиг хэргийн материалын дансанд 3-р сард 230.0 мянган төгрөгийн орлогыг анхан шатны баримт үндэслээгүй. 5 сард 70.0, 6 сард 355.7 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан.

422503103

5. Байгууллагын удирдлага дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй тухайн жилд зарцуулсан 9,651.3 сая төгрөгийн бараа материалын шаардах хуудсыг гарын үсгээр баталгаажуулаагүй. Анхан шатны хүчин төгөлдөр бус баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэсэн

Дээрх зөрчлүүд нь АДБОУС-200-гийн 64-д зааснаар бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 Үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан маягт, заавартай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бараа материалын тайлан болон цалин хөлсний зардлыг үнэн зөв тайлагнаагүй материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй байна. Тухайлбал цалин хөлстэй холбоотой ажил гүйлгээг аккруэл сууриар бус мөнгөн сууриар бүртгэсэн, бараа материалын тайланг улирал бүр бэлтгээгүй, байгууллагын удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ бүртгэж санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Аудитыг гүйцэтгэхэд бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэсэн эсэх талаар аудитын хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүссэн бөгөөд бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй тул хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Мөн санхүүгийн тайланд материаллаг хэмжээний өргөн тархсан аккруэль сууриар цалингийн гүйлгээг бүртгээгүй, тодруулга тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй тайлагнасан алдаа илэрсэн бөгөөд хэрэв залруулагдаагүй бол сөрөг дүгнэлт өгөх хэмжээнд хүрсэн тул гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,717,263.38	26,611,896.71
33	АВЛАГА	-	1,961,723.33
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	1,961,723.33
35	БАРАА МАТЕРИАЛ	14,717,263.38	24,650,173.38
351	Түүхий эд материал	9,875,753.38	16,840,603.38
35110	Тусгай зориулалттай материал	9,875,753.38	16,840,603.38
354	Хангамжийн материал	4,841,510.00	7,809,570.00
35410	Бичиг хэргийн материал	1,034,000.00	1,649,760.00
35420	Аж ахуйн материал	3,807,510.00	5,188,810.00
35470	Бусад хангамжийн материал	-	971,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	141,471,031.02	154,139,791.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	141,471,031.02	154,139,791.44
392	Биет хөрөнгө	128,691,031.02	141,359,791.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,085,500.00	159,895,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,781,208.67)	(62,228,727.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,880,000.00	18,180,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,737,223.28)	(8,587,889.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,291,647.93	4,291,647.93
39215	Хуримтлагдсан элэгдэл	(47,684.96)	(190,739.84)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	30,000,000.00	30,000,000.00
393	Биет бус хөрөнгө	12,780,000.00	12,780,000.00
39301	Програм хангамж	1,320,000.00	1,320,000.00
39305	Газар эзэмших эрх	11,460,000.00	11,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	156,188,294.40	180,751,688.15
4	ӨР ТӨЛБӨР	-	600,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	600,000.00
413	Өглөг	-	600,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	600,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ	156,188,294.40	180,151,688.15
512	Хуримтлагдсан үр дүн	156,188,294.40	180,151,688.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	23,423,328.93
51210	Өмнөх үеийн үр дүн	156,188,294.40	156,728,359.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	156,188,294.40	180,751,688.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	427,959,734.8	529,276,400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,442,179.8	89,341,850.0
120	Нийтлэг татварын бус орлого	167,442,179.8	89,341,850.0

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,460,710.0	38,410,200.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,460,710.0	38,410,200.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	138,675,939.7	49,830,000.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	24,305,530.1	1,101,650.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	260,517,555.0	439,934,550.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	156,111,500.0	374,180,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156,111,500.0	374,180,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,406,055.0	65,754,250.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,406,055.0	65,754,250.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	271,771,440.4	505,853,071.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,771,440.4	505,853,071.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,496,716.6	454,901,207.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,650,214.5	295,001,946.0
210101	Үндсэн цалин	93,761,968.1	172,635,308.5
210102	Нэмэгдэл	32,271,607.4	80,029,370.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,118,748.1	14,845,000.0
210104	Урамшуулал	13,039,815.9	20,866,500.0
210105	Гэрээт ажлын хөлс	458,075.0	6,625,766.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,554,338.6	37,795,505.4
210201	Тэтгэврийн даатгал	12,823,171.7	24,479,088.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,508,608.5	2,926,350.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,171,686.8	2,327,354.2
210204	Ажилгүйдлийн даатгал	269,426.2	1,439,946.4
210205	Эрүүл мэндийн даатгал	2,781,445.5	6,622,766.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,094,676.0	42,012,059.0
210301	Гэрэл, цахилгаан	1,399,193.0	1,900,673.0
210302	Түлш, халаалт	2,699,345.0	7,244,584.0
210303	Цэвэр, бохир ус	996,138.0	2,866,802.0
210304	Байрны түрээс	15,000,000.0	30,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,913,916.0	9,370,320.0
210401	Бичиг хэрэг	1,175,930.0	2,273,590.0
210402	Тээвэр, шатахуун	800,000.0	1,910,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	839,006.0	2,372,730.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	110,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,098,980.0	2,704,000.0
2105	Нормативт зардал	-	350,000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	350,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,000.0	2,450,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	165,000.0	-
210604	Урсгал засвар	-	2,450,000.0
2107	Томилолт, зочны зардал	1,937,000.0	8,568,000.0
210702	Дотоод албан томилолт	1,937,000.0	8,568,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,645,626.0	3,564,138.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,645,626.0	686,138.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,578,000.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	300,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,535,945.4	55,789,239.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,767,036.8	4,985,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,654,000.0	363,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,114,908.7	50,441,239.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,274,723.8	50,951,863.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	18,090,500.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,590,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,500,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,274,723.8	32,861,363.1
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,274,723.8	32,861,363.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)	156,188,294.4	23,423,328.9
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI = IV - V)	-	-
7	НИЙТ ҮР ДҮН (VII = III + VI)	156,188,294.4	23,423,328.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	264,978,265	478,344,750
I.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	264,978,265	478,344,750
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,460,710	38,410,200
120	Нийтлэг татварын бус орлого	4,460,710	38,410,200
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,460,710	38,410,200
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,460,710	38,410,200
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	260,517,555	439,934,550
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	156,111,500	374,180,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156,111,500	374,180,300
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,406,055	65,754,250
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,406,055	65,754,250
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	250,068,265	465,064,750
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,068,265	465,064,750
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	197,793,541	414,112,887
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,650,214	296,419,329
210101	Үндсэн цалин	93,761,968	174,942,970
210102	Нэмэгдэл	32,271,607	80,713,343

210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,118,748	14,535,000
210104	Урамшуулал	13,039,816	20,323,206
210105	Гэрээт ажлын хөлс	458,075	5,904,811
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,554,339	37,199,781
210201	Тэтгэврийн даатгал	12,823,172	24,660,822
210202	Тэтгэмжийн даатгал	1,508,608	2,947,731
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,171,687	2,338,044
210204	Ажилгүйдлийн даатгал	269,426	1,450,637
210205	Эрүүл мэндийн даатгал	2,781,446	5,802,546
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,094,676	42,012,059
210301	Гэрэл, цахилгаан	1,399,193	1,900,673
210302	Түлш, халаалт	2,699,345	7,244,584
210303	Цэвэр, бохир ус	996,138	2,866,802
210304	Байрны түрээс	15,000,000	30,000,000
2104	Хангамж, бараа материалын зардал	4,083,686	8,993,230
210401	Бичиг хэрэг	816,630	1,683,700
210402	Тээвэр, шатахуун	800,000	1,910,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	839,006	2,372,730
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	110,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,628,050	2,916,800
2105	Нормативт зардал	-	11,191,850
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	7,961,850
210502	Хоол, хүнс	-	1,730,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,000	2,546,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	165,000	-
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	-	2,546,000
2107	Томилолт, зочны зардал	1,937,000	8,568,000
210702	Дотоод албан томилолт	1,937,000	8,568,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,645,626	3,564,138
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,645,626	686,138
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,578,000
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	300,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,663,000	3,618,500
210901	Бараа үйлчилгээний бусад зардал/Бараа үйлчилгээний бусад зардал	9,000	3,255,500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,654,000	363,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,274,724	50,951,863
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	18,090,500
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,590,500
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,500,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,274,724	32,861,363
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,274,724	32,861,363

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III = I -II)	14,910,000	13,280,000
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,910,000	13,280,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,910,000	13,280,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,910,000	13,280,000
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(14,910,000)	(13,280,000)
.	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX = VII -VIII)	-	-
XII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
XIII	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
XIV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь орлолцооны нийт дүн
C01	2023 ОНЫ 01 САРЫН 01-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	156,188,294.4	156,188,294.4
C08	2023 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	-	-	156,188,294.4	156,188,294.4
D01	2023 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	-	-	312,376,588.8	312,376,588.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(155,648,229.6)	(155,648,229.6)
D03	ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ	-	-	156,728,359.2	156,728,359.2
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	23,423,328.9	23,423,328.9
D09	2024 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	-	-	180,151,688.2	180,151,688.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,180,300.0	380,326,914.6	5,853,385.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,180,300.0	380,326,914.6	5,853,385.4
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,089,800.0	372,236,414.6	5,853,385.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,322,000.0	253,279,624.6	42,375.4
210101	Үндсэн цалин	165,509,000.0	160,244,008.2	5,264,991.8
210102	Нэмэгдэл	56,871,000.0	52,272,600.0	4,598,400.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,470,000.0	14,535,000.0	935,000.0
210104	Урамшуулал	15,472,000.0	20,323,205.7	(4,851,205.7)
210105	гэрээт ажлын хөлс		5,904,810.7	(5,904,810.7)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,665,200.0	29,319,151.0	2,346,049.0
210201	Тэтгэврийн даатгал	21,532,400.0	19,459,888.2	2,072,511.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,533,200.0	2,329,256.5	203,943.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,266,600.0	1,806,509.8	(539,909.8)
210204	Ажилгүйдлийн даатгал	1,266,600.0	1,144,699.3	121,900.7
210205	Эрүүл мэндийн даатгал	5,066,400.0	4,578,797.2	487,602.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,750,000.0	42,012,059.0	2,737,941.0
210301	Гэрэл, цахилгаан	3,350,000.0	1,900,673.0	1,449,327.0
210302	Түлш, халаалт	9,100,000.0	7,244,584.0	1,855,416.0
210304	Байрны түрээс	30,000,000.0	30,000,000.0	-
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.0	2,866,802.0	(566,802.0)
2104	Хангамж, бараа материалын зардал	9,054,100.0	8,843,230.0	210,870.0
210401	Бичиг хэрэг	1,569,600.0	1,683,700.0	(114,100.0)
210402	Тээвэр, шатахуун	1,962,000.0	1,910,000.0	52,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,484,900.0	2,372,730.0	112,170.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	262,300.0	110,000.0	152,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,775,300.0	2,766,800.0	8,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,585,000.0	12,526,000.0	59,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.0	9,980,000.0	20,000.0
210604	Урсгал засвар	2,585,000.0	2,546,000.0	39,000.0
2105	Норматив зардал	11,232,500.0	11,191,850.0	
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	8,000,000.0	7,961,850.0	
210502	хоол хүнс	1,732,500.0	1,730,000.0	
210503	нормын хувцас	1,500,000.0	1,500,000.0	
2107	Томилолт, зочны зардал	8,626,000.0	8,568,000.0	58,000.0
210701	Дотоод албан томилолт	8,626,000.0	8,568,000.0	58,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,140,000.0	2,878,000.0	262,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.0	-	200,000.0

210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,620,000.0	2,578,000.0	42,000.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх	300,000.0	300,000.0	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,000.0	-	20,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,715,000.0	3,618,500.0	96,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,262,500.0	3,255,500.0	7,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	452,500.0	363,000.0	89,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,090,500.0	8,090,500.0	-
2133	Бусад урсгал шилжүүлэг	8,090,500.0	8,090,500.0	-
213209	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.0	500,000.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,590,500.0	7,590,500.0	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,180,300.0	406,736,814.6	(20,556,514.6)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	374,180,300.0	368,326,614.6	5,853,685.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	374,180,300.0	368,326,614.6	5,853,685.4
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.0	38,410,200.0	(26,410,200.0)
50	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	11.0	11.0	11.0
51	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-
52	Төсвийн байгууллага	1.0	1.0	-
53	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.0	11.0	11.0
54	Удирдах ажилтан	1.0	1.0	1.0
55	Гүйцэтгэх ажилтан	10.0	10.0	10.0
56	Үйлчлэх ажилтан			
57	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11.0	11.0	11.0
58	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.0	6.0	6.0
59	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.0	5.0	5.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,754,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,754,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,156,472.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,139,704.72
210101	Үндсэн цалин	14,698,962.15
210102	Нэмэгдэл	28,440,742.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,880,629.57
210201	Тэтгэврийн даатгал	5,200,934.08
210202	Тэтгэмжийн даатгал	618,474.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	531,534.42
210204	Ажилгүйдлийн даатгал	305,937.28
210205	Эрүүл мэндийн даатгал	1,223,749.20
2104	Хангамж, бараа материалын зардал	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300,000.00

210602	Тавилга	3,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	686,138.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	686,138.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	597,777.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	597,777.71
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,754,250.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,754,250.00
310001	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,754,250.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Шилэн дансны цахим хуудсыг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд Төсөв хөрөнгө зарцуулах, өр, авлага үүсгэх 115,611.6 мянган төгрөгийн 27 шийдвэр болон гэрээг мэдээлээгүй. 5 саяас дээш худалдан авсан 42,561.4 мянган төгрөгийн 2 үйлчилгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 42,799.5 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 дэх “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;”, 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, 6.4.8 дахь "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тухай бүр үнэн зөв оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 374,534.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд 356,776.3 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж 962.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 16,079.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 716.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Залруулсан алдаа:

1. Цалин, НДШ, ХХОАТ-ын 295,908.0 мянган төгрөгийн бичилтүүдийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнаж зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч аккрузель сууриар бүртгээгүй.

2. Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны 13,755.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тайлагнасан. Тайлант оны хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг 1,000.0 сая төгрөгөөр дутуу, багаж хэрэгсэл худалдан авах зардлыг - 300.0 мянган төгрөгөөр тус тус тайлагнасан.

3. Харилцах данс болон мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 600.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

4. Санхүүгийн байдлын тайланд татварын илүү төлөлт 1,961.7 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан.

5. Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 1,608.0 мянган төгрөгийн вирусийн эсрэг программ болон Office программын хугацаатай лицензийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн.

6. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд хуримтлагдсан элэгдлийг 41,132.2 мянган төгрөгийг бууруулж тайлагнаснаас үлдэгдэл өртөг нэмэгдсэн

7. Санхүүгийн үр тайланд цалингийн зардлыг 511.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тээвэр шатахууны 616.8 мянган төгрөгийн зардлыг жолоочийн тооцооны хуудасгүй, анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;", 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-дэх “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт гэж заасныг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан шатахууны зардлыг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

5.1.2 Тэтгэвэрт гарсан ажилтнаас энгийн ажилтны хувь хэмжээгээр нийгмийн даатгал суутгаж 99.7 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-дэх "Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө;," 19 дүгээр зүйлийн 19.1-дэх "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна", 21 дүгээр зүйлийн 21.1-дэх "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө.", 32 дугаар зүйлийн 32.2.2-дэх "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" гэж заасныг тус тус зөрчсөн ба үнэлгээ ба хуваарилалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгож өр төлбөр бүртгээгүй цалин хөлс болох 99.7 мянган төгрөгийг буцаан олгох төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

5.2.1 Нэг ажилтны 201.0 мянган төгрөгийн цалин хөлсийг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх Үнэн зөв байх, 20 дугаар зүйлийн 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-дэх “орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь

хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан цалин хөлс болох 201.0 мянган төгрөгийг нөхөн тайлагнах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.2.2 Жолоочийн тооцооны хуудсыг холбогдох заавар журмын дагуу хөтлөөгүй /спидометрийн заалтгүй, гүйцэтгэсэн ажил үүргийг бичээгүй, зарцуулсан шатахууны тооцоог хийгээгүй/, Бусад хангамжийн материал дансны нярвын тайланг бэлтгээгүй, үлдэгдлийг бараа материалын тодруулга тайланд тайлагнаагүй. Тусгай зориулалтын материал данснаас 194.7 мянган төгрөгийг зарцуулахдаа анхан шатны баримтад үндэслээгүй, 12 сарын тайланг бэлтгэхгүйгээр 1,642.0 мянган төгрөгийн орлого бүртгэсэн. Бичиг хэргийн материалын дансанд 3-р сард 230.0 мянган төгрөгийн орлогыг анхан шатны баримт үндэслээгүй. 5 сард 70.0, 6 сард 355.7 мянган төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх Үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн 13.5-дэх "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 20.1.4-дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 20 дугаар зүйлийн 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар" гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.2.3 Байгууллагын удирдлага дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй тухайн жилд зарцуулсан 9,651.3 мянган төгрөгийн бараа материалын шаардах хуудсыг гарын үсгээр баталгаажуулаагүй. Анхан шатны хүчин төгөлдөр бус баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 13.5-дэх "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 20 дугаар зүйлийн 20.1.4-дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;", 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-дэх "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-т заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.2.4 Санхүүгийн тайланг аудитад хамруулж зөрчилгүй дүгнэлт авсан үндэслэлээр 1,471.0 мянган төгрөгийн урамшууллыг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж цалин хөлсний зардлаас олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх “Үнэн зөв байх”, 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-дэх “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалын хавсралт 210104 "Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ажлын үр дүнг, сар, улирал, жилээр үнэлэн олгох мөнгөн урамшуулал", 213209 "Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид голдуу хагас бүтэн жилийн эцэст 1 удаа олгох мөнгөн шагнал, урамшуулал" гэж заасныг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу НХМ-аар бараа материалын хөдөлгөөнийг бүртгээгүй. /БМ-2, БМ-3/

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-дэх “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-г тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх батлагдсан загвар маягтын дагуу бараа материалын хөдөлгөөнийг тухай бүр бүртгэх

2. Цалин хөлсний бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт Ажилтнаас суутгасан шүүхийн шийдвэрийн төлбөр 600.0 мянган төгрөгийг тухай бүр шилжүүлээгүй, санхүүгийн тайланд шаардлагагүй өр төлбөр үүсгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-дэх "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-дэх “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах; 6.4.8-дэх "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх."

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг батлагдсан төсвийн хүрээнд тухай бүр шилжүүлэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Цалин хөлсний бүртгэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Татварын хөнгөлөлтийг жилийн эцэст хянаж, давтан тооцоолоогүйгээс 12 ажилтанд 362.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг дутуу эдлүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-дэх "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-дэх "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-дэх "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:" гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хөнгөлөлтийг жилийн эцэст тооцож хуульд заасан хувь хэмжээгээр хөнгөлөлт олгох, дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх

4. Орлогын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт Орлого бүрдүүлэлт, бүртгэл тайлагналын байдалд тавих хяналт хангалтгүй. Гэрээг бүрэн дүгнээгүй, нягтлан бодогч, мэргэжилтэн нар тооцоо нийлж орлогоо бүрэн бүртгэсэн эсэхийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-дахь "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-дахь "бүх орлого", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-дахь "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;" , 41 дүгээр зүйлийн 41.2.1-дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, бүртгэлийн дэвтрийг дансны хуулгатай тулган, хариуцсан мэргэжилтэнтэй сар бүр тооцоо нийлэх, гэрээг тухай бүр дүгнэх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХЗХ	7	356,776.3			7	356,776.3	7	356,776.3	7	356,776.3		
Дүн	7	356,776.3			7	356,776.3	7	356,776.3	7	356,776.3		

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХЗХ	10	17,758.4	2	716.5	4	16,079.9	4	962.0
Дүн	10	17,758.4	2	716.5	4	16,079.9	4	962.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
СХЗХ	1	200,972.3			1	200,972.3		
Дүн	1	200,972.3			1	200,972.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
СХЗХ								
Дүн								
Нийт дүн	1	200,972.3			1	200,972.3		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		